



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

“Эрүүл мэндийн салбарт 2021 оноос хэрэгжүүлэх шинэчлэлийн бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны хүрээнд цахим, технологийн бэлтгэлийг эрчимжүүлэх тухай

Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит бус чуулганы хуралдаанаар “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11.3.-д “...Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг төсвийн сарын хуваарийг үндэслэн гүйцэтгэлээр тооцож олгох бөгөөд Нийгмийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан гэрээний дагуу зардлын урьдчилгаа төлбөр олгож болно; 23.2.3.-д “... эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх” гэж заасан.

Энэхүү хуулийн өөрчлөлтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжихээр хуульчилсан.

Дээрх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж гүйцэтгэлээр тооцон санхүүжих байгууллага нь мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, програм хангамжийн бэлэн байдлыг хангаж, даатгуулагчид шуурхай, чирэгдэлгүй, чанартай, тусламж, үйлчилгээ үзүүлэхийг ДААЛГАСУГАЙ.

Үүнд:

Нэг. Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт:


- 1.1 “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу хуулийн хэрэгжилтийн хугацаатай уялдуулан бүх талын хүний нөөц, компьютер, тоног төхөөрөмж, програм хангамжийн бэлтгэл ажлыг хангах, харьяа эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж, удирдлага чиглэл өгч, мэргэжил арга зүйгээр хангах;
- 1.2 Эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглах програм хангамжгүй байгууллагуудад шаардлага хангасан програм хангамж нэвтрүүлэх, програм хангамжтай байгууллагуудад шаардлагатай модулийн ашиглалтыг бий болгох;

143200048

1.3 Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал болон интернетийн хурд, түүний тасралтгүй байдалд тогтмол хяналт тавих ажилтныг товлож үйл ажиллагаанд нь хяналт тавих;

Хоёр. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт:

- 2.1 Эрүүл мэндийн даатгалын тухай хууль"-д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу хуулийн хэрэгжилтийн хугацаатай уялдуулан бэлтгэл ажлыг хангах;
- 2.2 Програм хангамж ашиглан эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд амбулаторийн үзлэг, өвчний түүх, яаралтай тусламжийн үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, эмийн модуль зэрэг бүрэлдэхүүн хэсгийг цахим хэлбэрт шилжүүлж програм хангамжийг үйл ажиллагаандаа ашиглах;
- 2.3 Програм хангамжгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд шалгуур хангасан эмнэлгийн програм хангамж нэвтрүүлэн дээрх бүрэлдэхүүн хэсгийг ашигладаг болох;
- 2.4 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг програм хангамжийг ашиглах мэдлэг, чадварт сургах, бэлтгэл ажлыг хангах;
- 2.5 Эмч, эмнэлгийн мэргэжилтний тусламж, үйлчилгээ үзүүлэх програм хангамж болон бусад мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг бүрэн бүрдүүлэх;

САЙД  Т.МӨНХСАЙХАН